



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/004/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Сүхбаатар сум

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр
Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө:	12
3.4.2 Авлага:	12
3.4.3 Бараа материал:	12
3.4.4 Үндсэн хөрөнгө:	13
3.4.5 Өр төлбөр	14
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6.1 Завсрын аудитын талаар	20
4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Г.ЦЭНДСҮРЭН ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 10А-2025/004/НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Улсын онцгой комиссоос 106,900.0 мянган төгрөгийн автомашин, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 251,665.7 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 43,141.48 мянган төгрөгийн барилга байгууламж, 132,215.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 424,121.0 мянган төгрөгийн явган хүний зам болон гэрэлтүүлэг зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Шаамар-Цагааннуур сумын авто замын ажилд шаардагдах хайрганы карьерын төлбөрийг Засгийн газраас чөлөөлсөн болон аймгийн ИТХ-аас мод бэлтгэх хуваарьт өөрчлөлт оруулан, бэлтгэх модны хэмжээг бууруулснаас шалтгаалан тус сумын төсвийн орлогын төлөвлөгөө 164,143.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Цагааннуур сумын Засаг дарга нь тайлант онд 5 бүлэг 16 зорилт, 168 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.2 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,364,622.6	961,342.2
31	Мөнгөн хөрөнгө	1,067,660.5	662,155.3
33	Авлага	217,989.5	155,857.5
35	Бараа материал	78,972.6	143,329.5
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,823,642.2	10,631,033.9
39	Үндсэн хөрөнгө	9,823,642.2	10,631,033.9
39200	Биет хөрөнгө	9,748,263.5	10,514,591.4
39300	Биет бус хөрөнгө	75,378.8	116,442.5
3	Нийт хөрөнгийн дүн iii=i+ii	11,188,264.9	11,592,376.2
4	Нийт өр төлбөр	44,529.5	2,367.9
41	Богино хугацаат өр төлбөр	44,529.5	2,367.9
41300	Өглөг	44,529.5	2,367.9
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,143,735.4	11,590,008.2
51	Засгийн газрын хувь оролцоо	11,143,735.4	11,590,008.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,588,489.6	1,588,489.6
51200	Хуримтлагдсан үр дүн	8,836,718.0	9,282,990.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	718,527.7	718,527.7
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн vi=iv+v	11,188,264.9	11,592,376.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	Үйл ажиллагааны орлогын дун (i)	4,716,795.2	4,586,421.9
11	Татварын орлого	1,746,992.9	1,587,399.8
110	Орлогын албан татвар	692,290.9	1,116,005.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	723,549.6	1,154,162.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-31,258.7	-38,157.4
113	Хөрөнгийн албан татвар	241,401.9	242,870.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	813,300.2	228,524.0
12	Татварын бус орлого	2,050,724.8	1,609,247.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,050,724.8	1,609,247.0
13	Тусламж, санхүүжилтийн орлого	919,077.5	1,389,775.1
II	Үйл ажиллагааны зардлын дүн	2,594,426.2	3,072,688.5
21	Урсгал зардал	2,594,426.2	3,072,688.5
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,554,639.0	2,994,603.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	707,506.4	1,140,570.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,373.0	141,882.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,799.5	492,553.3
2104	Хангамж, бараа материалын зардал	68,892.5	66,794.5
2105	Нормативт зардал	2,238.0	2,458.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	394,723.6	174,077.3
2107	Томилолт, зочны зардал	16,500.7	15,550.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	485,416.8	39,103.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	720,188.5	921,613.1
213	Урсгал шилжүүлэг	39,787.2	78,084.9

III	Үйл ажиллагааны ур дун (iii)=(i)-(ii)	2,122,369.0	1,513,733.4
V	Үйл ажиллагааны бус зардлын дун	402,781.8	1,074,590.2
VI	Үйл ажиллагааны нийт ур дун (vi)=(iii)+(iv)-(v)	1,719,587.3	439,143.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,399,614.4	9,399,614.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	24,533.7	24,533.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,424,148.1	9,424,148.1
9	Тайлант үеийн үр дүн	1,719,587.3	1,719,587.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,143,735.4	11,143,735.4
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,143,735.4	11,143,735.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,129.7	7,129.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,150,865.1	11,150,865.1
19	Тайлант үеийн үр дүн	439,143.2	439,143.2
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,590,008.2	11,590,008.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дун (i)	2,849,691.7	3,109,715.3
11	Татварын орлого	1,746,992.9	1,587,399.8
110	Орлогын албан татвар	692,290.9	1,116,005.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	723,549.6	1,154,162.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-31,258.7	-38,157.4
113	Хөрөнгийн албан татвар	241,401.9	242,870.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	813,300.2	228,524.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	379,837.1	9,937.4
1181	Газрын төлбөр	327,937.2	120,065.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	105,526.0	98,521.2
12	Татварын бус орлого	183,621.3	132,540.4
120	Нийтлэг татварын бус орлого	183,621.3	132,540.4
13	Тусламж, санхүүжилтийн орлого	919,077.5	1,389,775.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,606,499.0	2,259,900.1
21	Урсгал зардал	1,606,499.0	2,259,900.1
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,566,711.8	2,181,405.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,699.2	1,140,570.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,168.3	141,882.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,799.5	492,553.3
2104	Хангамж, бараа материалын зардал	65,142.5	66,658.5
2105	Нормативт зардал	2,238.0	2,458.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,839.1	107,274.3
2107	Томилолт, зочны зардал	16,500.7	15,550.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	485,416.8	39,103.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,907.6	175,354.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,787.2	78,494.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,243,192.7	849,815.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	723,217.4	1,255,729.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	723,217.4	1,255,729.9
2200	Дотоод эх үүсвэрээр	723,217.4	1,255,729.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-723,217.4	-1,255,729.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-88,400.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	88,400.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	431,575.3	-405,914.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	636,085.2	1,067,660.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,067,660.5	662,155.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,590,8796.4	3,492,289.1	(1,098,590.3)	76
21	Урсгал зардал	2,501,000.8	2,265,655.8	(235,345.0)	91
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,422,707.0	2,187,570.8	(235,136.2)	90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,151,126.1	1,136,587.6	(14,538.5)	99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,282.9	141,424.7	(5,858.2)	96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	506,420.6	492,553.266.3	(13,867.3)	97
2104	Хангамж, бараа материалын зардал	66,756.3	63,615.8	(3,140.5)	95
2105	Нормативт зардал	2,978.5	958.8	(2,019.7)	32
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	128,207.4	127,950.9	(256.5)	100
2107	Томилолт, зочны зардал	16,645.1	15,550.0	(1,095.1)	93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,842.4	38,795.0	(194,047.4)	17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170,447.8	170,134.7	(313.1)	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,293.7	78,084.9	(208.8)	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,293.7	78,084.9	(208.8)	100
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,994,878.6	1,226,633.3	(768,245.3)	61

23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	95,000.0	0.0	(95,000.0)	0
III	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	4,590,879.4	3,575,719.5	(1,015,159.9)	78
31	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	
31000 1	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,217,350.6	3,472,797.2	(744,553.4)	82
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	373,528.8	102,922.3	(270,606.5)	28
4	"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		266,588.60	266,588.60	
5	"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		350,019.00	350,019.00	
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	77	77	0	100
61	Байгууллагын тоо	3	3	0	100
62	Ажиллагсадын тоо	37	37	0	100
65	Орон тооны мэдээлэл	37	37	0	100
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,590,879.4	3,492,289.1	(1,098,590.3)	76

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	23,340.92
21	Урсгал зардал	23,340.92
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	22,931.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,982.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	457.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,042.66
2105	Нормативт зардал	1,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,840.18
2107	Томилолт, зочны зардал	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	708.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,399.40
213	Урсгал шилжүүлэг	409.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	0
3133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	409.43
I	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	23,340.92
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,340.92
III	Нийт цэвэр мөнгөн гуйлгээ (iii)=(ii)-(i)	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагааннуур сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг "Сумын Засаг даргыг үйл ажиллагаагаа явуулахад нь мэргэшлийн зөвлөгөө мэдээллээр хангах, зөвлөн туслах, төрийн үйлчилгээний тасралтгүй хэвийн жигд үйлчилгээг хангаж иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчилж ажиллана" гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны ИТХ-ын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2024 онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус сумын “Хоршоог хөгжүүлэх сангийн 2022-2023 оны үйл ажиллагааны үр дүн”-д хяналт, шалгалт хийж 1,284.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж төлбөрийн акт тогтоосон байна.

Мөн аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цагааннуур сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 910,546.31 мянган төгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,067,660.5	662,155.3	-405,505.2
Авлага	175,828.0	155,857.5	-19,970.5
Бараа материал	78,972.6	143,329.5	64,356.9
Үндсэн хөрөнгө	9,823,642.2	10,631,033.9	807,391.7
Нийт хөрөнгө	11,188,264.9	11,592,376.2	404,111.3
Өр төлбөр	44,529.5	2,367.9	-42,161.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,143,735.4	11,590,008.2	11,143,735.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,188,264.9	11,592,376.2	404,111.3

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө:

Нийт мөнгөн хөрөнгө эхний үлдэгдэл 1,067,660.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 662,155.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 405,505.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,067,660.5	662,155.2	-405,505.2
Төгрөг	1,067,660.5	662,155.2	-405,505.2
Төрийн сангийн харилцах	1,067,660.5	662,155.2	-405,505.2
Дүн	1,067,660.5	662,155.2	-405,505.2

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 312,136.2 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 246,212.3 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 103,806.7 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага:

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 175,827.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 155,857.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 19,970.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Авлага дун	175,827.9	155,857.5	-19,970.4
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	0.0
Зээлийн хүүгийн авлага	4,119.8	9,159.8	5,040.0
Бусад авлага	57.3	57.3	0.0
Хувь хүмүүст олгосон зээл	171,650.8	146,640.4	-25,010.4
Дүн	175,827.9	155,857.5	19,970.4

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон үндсэн зээлийн авлага төлөгдсөнөөс шалтгаалсан байна. Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- ХХС-ийн зээлийн 146,640.4 мянган төгрөг,
- Зээлийн хүүгийн 9,159.8 мянган төгрөг,
- Байгууллагаас авах авлага 57.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тайлагнагдсан байна.

3.4.3 Бараа материал:

Нийт бараа материал дансны эхний үлдэгдэл 78,972.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 143,329.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 64,356.9 мянган төгрөгөөр өссөн байна.

□ Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	78,972.6	143,329.5	64,356.9
Тусгай зориулалттай материал	1,160.0	570.0	(590.00)
Эм боох материал	-	-	-
Хангамжийн материал	77,812.6	142,759.5	64,946.9
Бичиг хэргийн материал	-	-	-
Аж ахуйн материал	77,597.2	142,614.1	65,016.9
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	-	-	-
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	215.4	145.4	(70.0)
Мал амьтад	-	-	-
Дүн	78,972.6	143,329.5	64,356.9

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд **341,584.8** мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, 45,477.8 мянган төгрөгийн зураг төсөв, байгаль хамгаалагчийн хувцсыг үнэ төлбөргүй хүлээн авсан, 322,705.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 880,041.6 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, бусад хангамжийн материалын дансаар дамжуулан ашиглагч байгууллагуудад шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэлд:

- ЗДТГ - 125,401.4 мянган төгрөг,
- Ойн анги - 8,158.0 мянган төгрөг,
- Спорт цогцолбор - 9,770.1 мянган төгрөгийн үлдэгдэл тус тус байршиж байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө:

Нийт үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 9,823,642.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 10,630,486.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 806,844.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	9,748,263.5	10,514,044.1	765,780.6
Барилга, байгууламж	7,221,905.2	7,309,121.6	87,216.4
Автотээврийн хэрэгсэл	365,306.7	728,508.8	363,202.1
Машин тоног төхөөрөмж	523,716.1	787,008.8	263,292.7
Тавилга эд хогшил	97,248.7	86,812.0	-10,436.7
Бусад үндсэн хөрөнгө	4,102,660.6	4,682,561.5	579,900.9
Дуусаагүй барилга	143,183.2	43,116.8	-100,066.4
Биет бус хөрөнгө	75,378.8	116,442.5	41,063.7
Бусад биет бус хөрөнгө	76,753.0	119,191.0	42,438.0
Дүн	9,823,642.3	10,630,486.6	806,844.3

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 806,844.3 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 266,853.0 мянган төгрөгийн хөрөнгө /23,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 64,956.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 178,896.6 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө/ худалдан авсан,
- БОАЖГ-аас 5,760.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Аймгийн тамгын газраас 6,762.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Улсын онцгой комсоос 106,900.0 мянган төгрөгийн автомашин, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 251,665.67 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 43,141.48 мянган төгрөгийн барилга байгууламж, 132,215.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 424,121.0 мянган төгрөгийн явган хүний зам болон гэрэлтүүлэг зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэсэн байна.
- Ойн ангиас 7,321.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, ЗДТГ-аас 33,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 7,209.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж зэрэг нийт 47,531.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан,
- Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй ОНХС-аар хийгдсэн 63,072.8 мянган төгрөгийн 2 хөрөнгө оруулалтыг улсын комиссоор хүлээн авч хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн зэргээс шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 28,889.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,367.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 26,521.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1,988.2	0.0	-1,988.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	24,533.7	0.0	-24,533.7
Байгууллагад төлөх өглөг	2,367.9	2,367.9	0.0
Дүн	28,889.8	2,367.9	-26,521.9

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст өр төлбөр данс үлдэгдэл нь 26,521.9 мянган төгрөгөөр буурсан нь Спорт цогцолборын халаалтын зардалтай холбоотой 24,533.7 мянган төгрөгийн өглөгийг барагдуулснаас шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 9,359,802.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,911,028.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,588,489.6	1,588,489.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	7,092,597.1	8,836,718.1	1,744,121.0
Өмнөх үеийн үр дүн	12,001,833.0	7,117,130.8	-4,884,702.2
Тайлант үеийн үр дүн	-4,909,235.9	1,719,587.3	6,628,823.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	718,527.7	718,527.7	0.0
Дүн	9,399,614.4	11,143,735.4	1,744,121.0

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 1,744,121.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Цагааннуур сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 127 дугаар тогтоолоор 1,740,661.4 мянган төгрөгийн татварын орлого, 40,500.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,617,017.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 9.2 хувиар тасалсан байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Зөрүү
Татварын орлого	1,740,661.4	1,587,399.8	91.2	(153,261.7)
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын суутган	618,947.1	784,289.6	126.7	165,342.5
Үйл ажиллагааны орлого	104,796.8	300,083.6	286.3	195,286.8
Хөрөнгийн орлого	55,480.6	64,421.7	116.1	8,941.1
Хөрөнгө борлуулсны орлого	6,164.5	5,367.6	87.1	(796.9)
Бууны албан татвар	1,500.0	2,100.0	140.0	600.0
Малд ногдуулах албан татвар	320,205.3	181,589.3	56.7	(138,616.0)
ҮХХАТатвар	44,500.0	59,181.4	133.0	14,681.4
Улсын тэмдэгийн хураамж	3,700.0	5,151.4	139.2	1,451.4
Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	305,651.7		-	(305,651.7)
Хог хаягдал үйлчилгээ	4,000.0	4,786.0	119.7	786.0
Газрын төлбөр	65,000.0	81,214.1	124.9	16,214.1
Дуудлага худалдааны орлого	15,000.0	38,851.3	259.0	23,851.3
ХХОАТ-ын буцаалт	(38,157.4)	(38,157.4)	100.0	-
Ойн дагалт баялаг ашигласны төлбөр	221,512.8	97,003.0	43.8	(124,509.8)
Агнуурын нөөц ашигласны төлбөр	2,360.0	560.0	23.7	(1,800.0)
Байгалийн ургамал ашигласны төлбөр	10,000.0	958.2	9.6	(9,041.8)
Татварын бус орлого	40,500.0	29,618.1	73.1	(10,881.9)
Бусад орлого	500.0	7,210.0	1,442.0	6,710.0
Торгуулийн орлого	40,000.0	22,408.1	56.0	(17,591.9)
Нийт дүн	1,781,161.40	1,617,017.8	90.8	(164,143.6)

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 165,342.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2024 оны 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Үйл ажиллагааны орлого 195,286.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь Эрдэнэс таван толгойн хувьцааны ногдол ашиг орж ирснээс шалтгаалсан,
- Газрын дуудлага худалдааны орлого 235,272.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь хураагдсан модны болон үйлчилгээ явуулах газрын дуудлага худалдааны орлого нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Дуудлага худалдааны орлого 23,851.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь үйлчилгээний газрын дуудлага худалдаа 3 удаа явагдсанаас голлон шалтгаалсан байна.
- Газрын төлбөрийн орлого 16,214.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь урьд оны төлөгдөөгүй газрын төлбөр орж ирснээс тус тус шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлого 305,651.7 мянган төгрөгөөр тасарсан нь 2024 онд ЗГ-аас Шаамар-Цагааннуур сумын авто замын карерын төлбөрийг чөлөөлснөөс шалтгаалсан,
- Ойн дагалт баялаг ашигласны төлбөрийн орлого 124,509.8 мянган төгрөгөөр тасарсан нь аймгийн ИТХ-аас мод бэлтгэх хуваарьт өөрчлөлт оруулан, бэлтгэх модны хэмжээг бууруулснаас,
- Малд ногдуулах албан татварын орлого 138,616.0 мянган төгрөгөөр тасарсан нь тооцсон татварыг бүрэн төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 298,743.6 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос **876,830.0** мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг 1,176,073.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 109 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,871,115.6 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 456,093.0 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлогыг 89,567.5 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 815,134.9 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 700,000.0 мянган төгрөг, ХХС-ийн орлогоос 24,645.0 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 525,181.3 мянган төгрөг, ХХС-ийн урьд оны 74,135.0 мянган төгрөг зэрэг нийт **4,555,872.3** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 127 дугаар тогтоолоор дараах өөрчлөлт орж төсвийн орлого, зарлагыг **4,590,879.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- ОНХС-ийн эх үүсвэр болон зарлагыг 35,007.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,

- Аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 89,954.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, суурь орлогын дүнг 89,954.2 мянган төгрөгөөр бууруулсан,

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 546,047.2 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 850,142.0 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 700,000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, төсөвт газрын өөрийн орлогоос 89,567.5 мянган төгрөгийг, ХХС-ийн орлогоос 24,645.0 мянган төгрөгийг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 525,181.3 мянган төгрөгийг, ХХС-ийн урьд оны үлдэгдлээс 74,135.0 мянган төгрөгийг, орон нутгийн орлогоос 1,781,161.4 мянган төгрөгийг зэрэг нийт **4,590,879.4** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 546,047.2 мянган төгрөгийг аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 820,387.0 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 1,617,017.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 71,710.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 525,181.3 мянган төгрөгийг 700,000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, ХХС-ийн орлогоос 31,212.3 мянган төгрөгийг, ХХС-ийн урьд оны үлдэгдлээс 74,135.0 мянган төгрөгийг зэрэг нийт **4,385,690.7** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **3,492,289.0** мянган төгрөг буюу **76.1** хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 20,396.6 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 13,867.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 194,047.4 сая төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийг 95,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 28 төсөл, арга хэмжээнд 1,695,528.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 948,879.5 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 246,212.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь малын тоо толгойн албан татварын орлогын бүрэн бүрдээгүй, урьд оны өр төлбөр барагдаагүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 3,773.1 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 1,483.7 мянган төгрөг, БТСГ-аас 800.0 мянган төгрөг, Ойн газраас 9,200.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,084.1 мянган төгрөг зэрэг нийт 23,340.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж урсгал зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 25 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Худалдан авах ажиллагаа

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Шууд худалдан авалт		Харьцуулалтын арга		Гэрээ шууд байгуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	18	886,134.0	5	84,500.0	11	725,534.0	2	76,100.0
Сумын ОНХО	7	309,350.0	2	38,300.0	5	271,050.0	-	-

Эх сурвалж: www.tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагааннуур сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 91 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,594,426.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу

25,944.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн, автомашинуудыг цэнхэр дугаар тавьсан, зайлшгүй шаардлагатай зардлаас бусад зардлыг танасан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зардлуудыг хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтыг зөрчин Сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зургийг хадгалан үлдээх зорилгоор 4,879.6 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хүлээж аваагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн данс

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	181	181	-	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	183	-	
3	Засаг даргын Тамгын газар	183	183	-	
4	Орхон бүсийн ойн анги	183	183	-	
	Нийт дүн	730	730	-	

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 730 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж үзлээ.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 172 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	6,735.0	1	6,735.0	100.0
Албан шаардлага	1	1,905.0	1	1,905.0	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	3	8,640.0	3	8,640.0	100.0

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,465,865.2 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн 3,465,865.2 мянган төгрөг. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд богино хугацаат өр төлбөрийг 84,323.2 мянган төгрөгөөр илүү,

- *Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлого, зарлагын дүнг 3,381,542.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.*

Аудитаар нийт **15,690.0** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс **2,626.9** мянган төгрөгийн төлбөрийн акт, **13,063.1** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. ЗДТГ- Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан *“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”*-ыг үндэслэн орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 2 албан хаагчид олгосон **14,653.0** мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **1,465.3** мянган төгрөгийг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь *“Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”*, 6.3.1: *“... урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”*, 22 дугаар зүйлийн 22.1 дэх *“Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”* 22.1.1: *“хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. ЗДТГ-Сануулах сахилгын шийтгэлтэй Хөдөө аж ахуйн тасгийн дарга Ч.Алтанхуягийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад улирлын ажлын үр дүнгийн урамшуулалд **1,161.6** мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төрийн албан тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь *“Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7 дахь *“Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад олгосон улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

ТТЗ:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. ЗДНХ-өөс жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой тохижилт үйлчилгээний буюу нохой устгалын зардалд **6,210.0** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан *“Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”*-ын 1.2 дахь *“... урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг ... гэж ойлгоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

2. ЗДТГ нь сүүлийн 3 жил дараалан буюу 2021 онд 4,112.7 мянган төгрөгийн, 2022 онд 6,196.1 мянган төгрөгийн, 2023 онд 8,163.1 мянган төгрөгийн буюу дунджаар **6,157.3** мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн атал, 2024 онд өөрийн орлогыг нэмэгдүүлэлгүйгээр 500.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,353.1 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөнөөс давсан **6,853.1** мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”*-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь *“Энэ журмын 3.1.1-т заасан орлого /төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/ -ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон...үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны орлогыг бодит гүйцэтгэлд үндэслэн үнэн зөв төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ТТЗ	2	3,465,865.2			2	3,465,865.2	2	3,465,865.2				
Дүн	2	3,465,865.2			2	3,465,865.2	2	3,465,865.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	3	9,480.0	2	2,626.9	1	6,853.1						
ЗДНХ	1	6,210.0			1	6,210.0						
ТТЗ-ийн Дүн	4	15,690.0	2	2,626.9	2	13,063.1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Терийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
ЗДТГ- нь түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулгасан	1	4,879.6			1	4,879.6		
Нийт дүн	1	4,879.6			1	4,879.6		